



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/163

Улаанбаатар хот

“Багахангай цом-2024” дартсын аварга
шалгаруулах тэмцээн зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир спортын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Дүүрэгт 2024 оныг “Бүтээмж хамтын ажиллагааг дээшлүүлэх жил” болгон зарласантай холбогдуулан иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хүүхэд залуучуудад дартсын спортыг түгээн дэлгэрүүлэх, дартс сонирхогчдын ур чадварыг нэмэгдүүлэх, дүүрэг орон нутгаа сурталчлах хүрээнд “Монголын дартс сонирхогчдын холбоо”-той хамтран “Багахангай цом-2024” дартсын аварга шалгаруулах тэмцээнийг 2024 оны 10 дугаар сарын 26,27 - ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн төсвийг хавсралтаар баталж, 2,190,000 (Хоёр сая нэг зуун ерэн мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3.Тэмцээнийг Дартсын дүрмийн дагуу зохион байгуулж, санхүүгийн тайланг ирүүлэхийг “Хос мэргэн” дартсын клуб (Д.Хүрэлбаатар)-т үүрэг болгосугай.


4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 10 сарын 17 ны өдрийн 1103 дугаар
захирамжийн хавсралт



“БАГАХАНГАЙ ЦОМ-2024” ДАРТСЫН
ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Бүгд үнэ
1	Хулдаасан хэвлэл	м2	12	12.000	144.000
2	Цом	ш	6	97.000	582.000
3	Медаль	ш	18	18.000	324.000
4	Өргөмжлөл	ш	18	15.000	270.000
5	Дартсын самбар	ш	3	200.000	600.000
6	Самбарын хүрээ	ш	3	90.000	270.000
Нийт үнэ:					2.190.000